

Бүлэг сэдэв	АГУУЛГА	Дасгал, алхам	Танин мэдэхүйн түвшин		
			Мэдэх, ойлгох	Задлан шинжлэх	Үнэлэх, бүтээх
Тоочин дүрсэлс эн эхийн үндсэн шинж	Тоочин дүрсэлсэн эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжлэх	Хэсэг 1 Дасгал 1-2			
	Эхэд тэмдэг нэр , хэрэглэсэн учрыг тайлбарлах	Хэсэг 2 Дасгал 1-4			
	Эхээс уран дүрслэлийн үүргийг тодруулах	Хэсэг 3 Дасгал 1-3			
	Эхэд эсрэг ба ойролцоо утгатай зэрэгцсэн нийлмэл үгийг сонгосон учрыг тайлбарлах	Хэсэг 4 Дасгал 1-2			
	Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн найруулгын үүргийг тайлбарлах	Хэсэг 5 Дасгал 1, 2			
Гадаад дотоод шинжийг тоочин дүрсэлж бичих	Гадаад дотоод шинжийг тоочин дүрсэлж бичих	Хэсэг 6 Дасгал 1-3			
	Зөв бичих	Хэсэг 7 Дасгал 1-9			
Тоочин дүрсэлсэн эхийг задлан шинжлэх, тоочин дүрсэлж бичих	Тоочин дүрсэлсэн эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжлэх	Дасгал 1 алхам 1-4			
	Тоочсон аргыг хэрэглүүрийг задлан шинжлэх	Дасгал 2 алхам 1-10			
	Тоочин дүрслэх арга хэрэглүүрийг задлан шинжлэх	Дасгал 3 алхам 1-4			
	Эхэд дуурайх, дүрслэх үгийг хэрэглэсэн учрыг тайлбарлах	Дасгал 4 алхам 1-6			
	Тоочин дүрсэлж эх зохион бичих	Дасгал 5			
Тоочсон эхийг задлан шинжлэх, тоочин бичих	Тоочсон эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжлэх	Дасгал 6 алхам 1			
	Эхэд тооны нэр хэрэглэсэн учрыг тайлбарлах	Дасгал 7 алхам 1-5			
	Илтгэх хуудас бичих	Дасгал 8 алхам 1-2			
	Танилцуулгыг уншиж, бүтэц, гол санааг тодорхойлох	Дасгал 9 алхам 1-3			
	Танилцуулга бичих	Дасгал 10			

1

Сурагчийн овог нэр: .....

Эхэлсэн .... он ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

**СЭДЭВ:** Эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоо:

**АГУУЛГЫН ТОВЧ ТАЙЛБАР:**  
**Эхийн бүтэц:** Эх цогцолбороос бүтэх бөгөөд эхлэл, гол, төгсгөл гэсэн 3 хэсэгтэй.  
**Эхийн эхлэл хэсэг:** Хэний, юуны тухай тоочин дүрслэх вэ? гэдгээ танилцуулах  
**Эхийн гол хэсэг:** Өгүүлж буй хүн, юм үзэгдлийнхээ дотоод, гадаад шинжийг тоочин дүрслэх  
**Эхийн төгсгөл хэсэг:** Эхлэл, гол хэсгийг дүгнэх  
**Эхийн агуулгын уялдаа холбоо:** Эхийн бүтцийн хэсгүүд хоорондоо уялдаа холбоотой байх бөгөөд “Эх бол агуулгын хувьд нэгэн бүхэл цогц юм.”


**Дасгал 1:** Эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилье

А. “Нацагдорж минь ийм хүн байлаа” эхийг бүтцийн хэсгээр задалсныг анхааралтай уншъя.

Б. Эхийн бүтцийн хэсэг тус бүрд юуны тухай өгүүлснийг харьцуулж ажиглая.

В. Эхийн хэсэг тус бүрийг холбож байгаа гол агуулга нь юу вэ? Дүгнэж бичье.

Нацагдорж минь ийм хүн байлаа.



**Дасгал 2:** Эхийг анхааралтай уншаад, бүтцээр задалж, агуулгын уялдаа холбоог дүгнэе.

**Миний найз**

Үнэнийг хэлэхэд надад олон сайн, үнэнч найз бий. Тэд бол манай ангийн охид хөвгүүд. Гэхдээ Удвал миний хамгийн сайн найз, бид хоёр 5 жил гаруй найзалж байна.

Тэр 13 настай. Удвал тийм ч өндөр биш, гэхдээ хэзээд сэтгэл булаам харагддаг. Найз маань долоо хоногт хоёр удаа иог, усан спортоор хичээллэдэг тул бие галбир нь үнэхээр эрүүл, чийрэг, тэгш сайхан. Миний найз шулуун, урт, хүрэндүү үстэй, тунгалаг бор нүдтэй, урт хар сормуустай бөгөөд үргэлж дэгжин хувцасладаг.

Ер нь найз маань үзэсгэлэнтэй, дур булаам охин. Гэхдээ миний бодлоор дотоод гоо сайхан нь бие махбодоос илүү чухал юм. Удвал бол хүмүүжилтэй, хөгжилтэй, сайхан сэтгэлтэй охин. Би авхаалжтай, мэдрэмжтэй, сэргэлэн цовоо, өгөөмөр сайхан сэтгэлтэй найзаараа бахархдаг даа.

<p>А. Эхийн эхлэл хэсгийг олъё. “Эхлэл хэсэг”-т юуны тухай өгүүлсэн бэ? .....</p>	<p>Эхийн гол хэсгийг олъё. “Гол хэсэг”-т юуны тухай өгүүлсэн бэ? .....</p>	<p>Эхийн төгсгөлийг олъё. “Төгсгөл хэсэг”-т юуны тухай өгүүлсэн бэ? .....</p>
<p>Б. Эхийн хэсэг тус бүрийг холбож байгаа гол агуулга нь юу вэ? гэдгийг бичье.</p>		
<p>В. “Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн агуулга нь хоорондоо уялдаа холбоотой байна” гэж дүгнэж болох уу? Яагаад вэ?</p>		
<p>Г. Найзынхаа тухай бичье гэвэл эхлэл, гол, хэсэгт юуны тухай бичих вэ? Дараах хэсэгт бичье</p>		
<p>Эхлэл хэсэгт:</p>	<p>Гол хэсэгт:</p>	<p>Төгсгөл хэсэгт</p>
<p>Д. Чи найзынхаа тухай эхлэл хэсэгт танилцуулаад, гол хэсэгт өөр хүний тухай бичиж болох уу?</p>		
<p>Е. “Эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоо” хэсгээс юу ойлгосноо эргэцүүлж, дүгнэж бичье.</p>		

2

Сурагчийн овог, нэр: .....

Эхэлсэн .... он ... сар... өдөр ... цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

**СЭДЭВ:** Эхэд тэмдэг нэр хэрэглэсэн учир.**АГУУЛГЫН ТОВЧ ТАЙЛБАР:**

**Тэмдэг нэр гэж юу вэ?** Юмс үзэгдлийн өнгө зүс, шинж чанар, хэмжээ, хэлбэр дүрсийг зааж ямар? гэсэн асуултад хариулагдан, нэр ба үйл үгэнд үндэс хэлбэрээр холбогдох үгийг тэмдэг нэр гэнэ.

**Тэмдэг нэрийн үнэлсэн зэрэг:**

- Ерийн утга: Цагаан цаас, улаан даавуу, халуун газар, хурдан морь
- Эрчимжүүлсэн утга: Цав цагаан цаас, час улаан даавуу, маш халуун газар (маш, нэн, тун, улам, үлэмж, цоо, цав, нов, ас, цэлдэн, чармай, пад, тас, шал, пиг, тэг...)
- Бууруулсан утга: Цагаавтар цаас, улаандуу даавуу, халуувтар газар (-втар,-втэр,-втор,-втөр), -дуу(-дүү, нгуй,-нгүй )

**Тэмдэг нэрийн харьцуулсан зэрэг:**

- Ижил зэрэг: цас шиг цагаан, мөс шиг хатуу
- Илүү зэрэг: цаснаас цагаан, мөснөөс хатуу
- Давуу зэрэг: хамгийн цагаан, бүхнээс ухаантай


**Дасгал 1:** Зураг дээрх хүүгийн царай төрх (нүд, хөмсөг, үс, чих, ам, хамар)-ийг тодорхойлж бичье.

**А.** Царай төрхийг тодорхойлсон тэмдэг нэрсийг уншъя. Чи нэмбэл ямар үг бичих вэ?

**Б.** Хүүгийн царай төрхийг илтгэх тэмдэг нэрийн мөр тус бүрээс 3, 3 үг сонгож, үнэлсэн зэрэг үүсгэж, утгын ялгааг ажиглая.

**В.** Сонгосон тэмдэг нэрээс харьцуулсан зэрэг үүсгэж, утгын ялгааг ажиглая.

**Г.** Бичсэн тэмдэг нэрээсээ хамгийн оновчтойг сонгон, хүүгийн царайг тодорхойлж бичье.

	Тэмдэг нэрээр (өнгө зүс, шинж чанар, хэмжээ, хэлбэр дүрс)	Тэмдэг нэрийн үнэлсэн зэрэг	Тэмдэг нэрийн харьцуулсан зэрэг
Нүд	Бор, цэнхэр, хар, хөнхөр, онигор, жартгар, алаг, бүлтгэр, бөлцгөр, торомгор,		Тэнгэр шиг цэнхэр,
Хөмсөг	Өтгөн, шулуун, нарийхан, өргөн, гоё, жирэвгэр		
Үс	Богино, урт, хүрэн, хар, буурал, өтгөн, буржгар, шулуун, долгионтой, хөвсгөр, шингэн		
Чих	Дэлдэн, хулгар, жижиг, том		
Хамар	Өргөн, намхан, шулуун, сартгар, монхор, шонтгор, өндөр, хянган, шантгар	Шантгардуу,	
Уруул	Зузаан, нимгэн, дарвагар, улаан, булбарай, дорвогор, цорвогор		
		Хүүгийн царайг тодорхойлж бичье.	

**Дасгал 3:** Хүний гадаад дотоод шинж гэж юу юуг хэлдгийг мэдье.

- А.** Өмнө бүтцээр задалсан “Нацагдорж минь ийм хүн байлаа” эхийн тэмдэг нэрийн доогуур зурж тэмдэглэе.
- Б.** Дор байгаа хүснэгтээс гадаад дотоод шинж гэж юу вэ? гэдгийг мэдэж авъя.
- В.** Хүснэгтэд их зохиолчийн гадаад, дотоод шинжийг илтгэсэн тэмдэг нэрийг ялгаж бичье.

Хүний гадаад шинжид юуг ойлгож болох вэ?	Хүний дотоод шинжид юуг ойлгож болох вэ?
<b>Гадаад шинж:</b> Тухайн хүний гар, хөл, үсний өнгө, засалт, хувцаслалт болон инээж буй байдал, дууны өнгө зэрэг гадаад төрхөөс илрэх бүхий л онцлогуудыг хэлнэ, Хүнийг бүхэлд нь дүрслэх албагүй, Хамгийн гол нь тэр хүний бусдаас ялгарах гол онцлогийг дүрслэх нь чухал юм.	<b>Дотоод шинж:</b> Уг хүний сонирхол, дадал зуршил, хүнд болон тухайн нөхцөл байдалд хэрхэн хандаж байгаа хандлага, бодол санаа, сэтгэл хөдлөл зэрэг дотоод ертөнцийн илрэх онцлогуудыг хэлнэ.

**Нацагдорж минь ийм хүн байлаа.**

**Нүүр царай**

**Бие галбир**  
нарийхан, тэгш шулуухан

**Хувцаслалт**



Их зохиолч  
Д.Нацагдорж

**Ааш зан**

**Давтагдашгүй чанар**  
...ихэрхэг бардам зангүй

**Яриа хөөрөө**

**Г.** Их зохиолч **Д.Нацагдорж ямар хүн байсан бэ?** гэдгийг түүнийг хөрөглөхөд сонгосон тэмдэг нэрийн утгаас үүдэн тайлбарлая.

- Үгийн утгыг тайлбар толиос харъя.**
- **Дөлгөөн даруу** – Номхон, түвшин, эелдэг
  - **Нөхөрсөг** – Хайр халамжтай, найрсаг, нөхрийн чанар сайн
  - **Хүндэтгэх** - Эрхэм чухал болгож хичээнгүйлэн хүндэлж үзэх
  - **Ихэрхэг** – Биеэ ихэд бодох
  - **Бардам** зангүй – Биеэ бусдаас илүүд үзэн эрдэхгүй.

Их зохиолчийн дотоод шинжийг дүрсэлсэн тэмдэг нэрийн утгаас харахад зохиолч маань ямар хүн байсан байна бэ? Бичье.

**Д.** <https://econtent.edu.mn/lessons/EBS/7rang/mon/3581> холбоосоор орж, “Тоочин дүрсэлсэн эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох” хичээлийг үзээд, өнөөдрийн болон өмнөх хичээлтэй холбоотой гол чухал санааг, товч бичье.

**Дасгал 4** Эхэд тэмдэг нэр хэрэглэсэн учрыг тайлбарлая.

А. Хоёр цогцолборын нэгийг сонгон уншаад, тэмдэг нэрийн доогуур зуръя.

Б. Сонгосон цогцолборт ямар утгатай (тэмдэг нэрийн утга: өнгө зүс, шинж чанар, хэмжээ, хэлбэр дүрсийг), ямар ямар тэмдэг нэрээр дүрээ тодорхойлсон бэ? гэдгийг тайлбарлаж бичье.

В. Эхэд тэмдэг нэр хэрэглэсэн учрыг тайлбарлан бичье.

**Нэг өгүүлбэрийг хамтдаа тайлбарлая.**

**Өгүүлбэр нь:** Өндөр гоолиг биетэй, тунгалаг цагаан царайтай шинэ хүрэн тэрмэн дээл дээр шар бүс ороосон дэгжин ламыг Цамба гэдэг бөгөөд энэ жил хорин гурван нас хүрчээ.

Б. Тайлбар: Өгүүлбэрт “Өндөр, гоолиг, тунгалаг, цагаан, шинэ, хүрэн, шар, дэгжин” гэсэн хэмжээ, чанар, өнгө заасан тэмдэг нэрээр дүрийн гадаад шинжийг тодотгон дүрсэлжээ.

В. Тайлбар:

- “Гоолиг” - гоо үзэмжтэй, биеийн харьцаа аятай сайхан
- “Тунгалаг” - эрүүл энх амгалан, гэрэл гэгээтэй
- “Дэгжин” - ганган хээнцэр гоёмсог

Г. Тайлбар: Зохиогч “Дүрээ гоё сайхан, ганган хээнцэр” гэсэн санааг илэрхийлэхийн тулд эдгээр тэмдэг нэрийг хэрэглэжээ.

1. Дунд зэргийн нуруутай, ясархаг туранхай, хацар нь сорогдсон юм шиг хонхойсон ясан шанаатай, өтгөн хөмсөгтэй, хурц ногоовтор нүдтэй, ширвээ сахалтай, ер нь яхир, ширүүн дориун хүн шиг. Гэвч ой ухаан саруул, яриа хөөртэй, эрт эдүүгээгийн бичиг номд нэвтэрсэн, эрдэмт хүн тул бишрэхээс өөр арга байсангүй



2. Миний аавын үнэр бол аавын царай төрх, дуу хоолой, инээмсэглэл, харц, үс, хуруу гар гээд буй байсан бүхнийх нь цогц илэрхийлэл юм. Миний аав их гоё хүнгэнэсэн намуун дуутай, гүн, ухаалаг тогтуун харцтай. Тэгэхээр та бод доо, аавын минь үнэр “намуухан ухаалаг”, бас энгийн, тэгсэн атал асар нөмөртэй, үе үе чанд цэх юм шиг атал халуун дулаан, тогтуун. Ертөнцөд өөр ийм үнэртэй хүн байна уу?

**Цогцолбор 1.**

Б. Тайлбар: .....

В. Тайлбар: .....

Г. Тайлбар: .....

**Цогцолбор 2.**

Б. Тайлбар: .....

В. Тайлбар: .....

Г. Тайлбар: .....

Эхэд тэмдэг нэр хэрэглэхийн учрыг чи юу гэж бодож байна вэ? Товч дүгнэе.

3

Сурагчийн овог, нэр: .....  
Эхэлсэн ... он ... сар... өдөр ... цаг  
Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

**СЭДЭВ:** Уран дүрслэлийн утга, үүрэг

**АГУУЛГЫН ТОВЧ ТАЙЛБАР:**  
**Уран дүрслэл:** Өгүүлж хэлэх санаагаа утга төгөлдөр, содон, сонирхолтой илэрхийлэх арга.  
**Адилтгал:** Юм үзэгдлийн аль нэг шинжийг товойлгон тодруулах зорилгоор түүнтэй төстэй өөр нэг юм үзэгдлийн нэрээр утга шилжүүлэн найруулах арга. Жишээ нь: Халхын тал шиг тэнэгэр ухаант хүү  
**Хүншүүлэл:** Хүний үг, үйлдлийг амьтан, юм үзэгдэлд шилжүүлэн адилтгаж дүрслэх найруулгын арга. Жишээ нь: Урьд та ийм байсан гэж Да хүрээг харуулбал Улаанбаатар хот маань элгээ хөштөл хөхөрнө байх  
**Ихэсгэл:** Юм үзэгдлийн аль нэг шинж чанарыг бодит боломжоос давуулж дүрслэх арга. Багасгал бол үүний эсрэг. Далан хүн даадаггүй далай цагаан шаазан, Аргийн чинээ бор гэр.

- Дасгал 1:** Уран дүрслэлийн утга, үүргийг тодруулъя.
- А. Өгүүлбэрээс уран дүрслэлийг олж, будъя.
  - Б. Өгүүлбэрт ямар уран дүрслэл хэрэглэснийг тодорхойлъё.
  - В. Уран дүрслэл яаж бүтсэнийг тайлбарлая.
  - Г. Уран дүрслэл нь хүний гадаад дотоод шинжийг дүрслэхэд ямар үүрэгтэй байна вэ?

**Нэг өгүүлбэрийг хамтдаа тайлбарлая.**

- Өгүүлбэр:** Халхын тал шиг тэнэгэр ухаант хүү.
- Б. “Халхын тал шиг тэнэгэр ухаант хүү” гэсэн өгүүлбэр нь адилтгалаар бүтжээ.
  - В. Хүний ухааны царааг зах хязгааргүй өргөн уудам тал нутагтай адилтгасан.
  - Г. Хүний уужим холч ухааныг тодотгох зорилгоор хэрэглэсэн.

**Тайлбарлах өгүүлбэрүүд:**

1. “Тэр хоёрын нэг Цээмаа хүүхэн зааны ясан савх шиг хуруутай гараараа нуурын ус шиг долгиотсон гил хар гэзгээ илээд, эрвээхэйн далавч шиг эрээн мяндсан алчуураар янзаган цагаан хүзүүгээ ороож, салхинд найгалзсан хонгорзул цэцэг шиг гунхалзан сууна.  
 Б.....  
 В. ....  
 Г. ....

2. Адайр ярдаг зан, адсаган хөх царай, өлөн чонын нүдтэй түүнээс юу хүлээх билээ.  
 Б.....  
 В. ....  
 Г. ....

3. ...Тавлаад суухаараа Тавин хоёр хүний зайд суудаг. Тахийгаад суухаараа Хорин таван хүний зайд суудаг Гүзээн Гүмбэ баатар  
 Б.....  
 Г. ....

“Мойл” гэсэн үгийг яагаад сонгосон бол?



Охин цав цагаан царайтай| мойл хар нүдтэй гэнэ.



**Дасгал 2:** Б.Лхагвасүрэнгийн “Өнжүүлийн хөх өвгөд” шүлгийг уншаад, шүлэгт ямар уран дүрслэл ямар үүрэгтэй байгааг тодруулъя.

**А.** Хүүхдүүд ээ, дараах шүлгийн тайлбарыг өмнөх дугаарын дагуу дэвтэртээ бичье.

### Өнжүүлийн хөх өвгөд (Б.Лхагвасүрэн)

Ард минь биш урд минь - 1. Шүлгийн мөрийн далд санааг ил болгон бичье.

Ааруул үнэртсэн үгээ хэлдэг – 2. Адилтгалаар бүтжээ. Яагаад адилтгал болох вэ?

Ил далд нэг л зантай - 3. Мөрийн санааг тайлбарлая. Энэ дүрийн дотоод шинж мөн үү?

Инээх нь хүртэл дугуй нартай – 4. Юуг юутай адилтгасан бэ? Зурж үзье.

Ухаантай өвгөд минь

Уулын оройн хадад минь – 5. Өвгөдийг яагаад уулын оройн хададтай адилтгасан бол?

Хэдэн улаан уул минь – 6. Адилтгал: Уулын өнгийг солибол утгад өөрчлөлт гарах уу?

Хэлхгэр дээлтэй туульс минь – 7. Өвгөдийг яагаад туульстай адилтгасан бол?

Талд багтдаггүй уртын дууг – 8. Уртын дууг яагаад талд багтахгүй гэж ихэсгэсэн бэ?

Тавган дээрх үзэм нуртал дуулж...9. Ямар уран дүрслэлээр бүтсэн бэ? Яагаад вэ?

Далиндаа хяруутай – 10. Үсний буурлыг хяруутай адилтгажээ. Яагаад юм бол?

Эр бор харцаганууд минь – 11. Адилтгалыг оновчтой болсныг батлан тайлбарлая

Өнгөрсөн он цагийн алтан гэрэгэ – 12. Алтан гэрэгэ – Хааны элч нарын биедээ авч явдаг, алт мөнгө ялтас дээр сийлсэн, итгэмжлэх бичиг бүхий пайз. Өвгөдтэй адилтгахын учир юу вэ?

Өнжүүлийн хөх өвгөд минь – 13. “Хөх” – өнгийг өөр өнгөөр сольж болох болов уу?

Аашаа эвдэхэд минь хошлон байдаг.

Алдаж оноход минь багана байдаг.

Гэр дэрвэхэд чагтага байдаг

Төр үймэхэд тулга байдаг. 14. Өвгөдийг гэрийн “Хошлон, багана, чагтага, тулга”- тай адилтгасан учрыг настай хүнээс асууж мэдэж авъя.

**Б.** Шүлгийг задлан тайлбарласнаар “Өвгөд”- ийн дүр зураг чамд яаж төсөөлөгдөж байна вэ? Ийм төсөөлөл, мэдрэмж төрөхөд уран дүрслэл ямар үүрэгтэй байна вэ? Дүгнэн бичье.

A decorative graphic of a house with a pink roof and a yellow body with white windows. Below the house is a large, light green rectangular area with horizontal lines, intended for writing answers.



**Дасгал 3:** “Тэмдэг нэр, уран дүрслэл”- ашиглан дотоод, гадаад шинжийг тоочин дүрсэлж бичье.

**А. Өгүүлбэрийн бүтцийг дуурайн, бичье. Түүний тулд өгүүлбэрийн бүтцийг сайтар ажиглаарай.**

**Өгүүлбэр:** Барзгар улаан нүүртэй, бүдүүн боргил дуутай, алиа хошин зантай хүн.

Дуурайж бичье. Цэгийн оронд тэмдэг нэр бичье.

....., ..... нүүртэй,  
 ..... дуутай,  
 ..... зантай хүн.

(Сонгосон тэмдэг нэр оновчтой болж чадсан уу?, Өөр тэмдэг нэрээр солиод уншаарай)

**Өгүүлбэр:** Гар нь хүрз мэт, хуруу нь бахь адил, алхаа нь баавгай мэт.

Дуурайж бичье. Цэгийн оронд уран дүрслэл бичье.

Гар нь .....  
 хуруу нь .....  
 алхаа нь .....

(Сонгосон адилтгал нь оновчтой болж чадсан уу? Хоёр зүйлийн төстэй шинжийг хэр сайн ажигласан бол?)

**Б. Хөвгүүд өөрийн гадаад шинж, охид дотоод шинжээ товч тоочин дүрсэлж бичье.**

- **Гадаад шинж:** Нүүр царай, алхаа гишгээ, хувцаслалт ... (Авхаалж самбаа, дохио зангаа, хөдөлгөөн, хобби.. )
- **Дотоод шинж:** Зан чанар, давтагдашгүй чанар, үг яриа ...(Шударга зан, өөртөө итгэх итгэл, бусдын төлөө гэсэн сэтгэл, махруу хичээнгүй, үнэнч, тусч ...)

**Өөрийнхөө ямар байгаагаас гадна ямар болохыг хүсэж байгаагаа бичих нь чухал шүү.**

Хүүгийн дүрийг сонгосон бол гадаад шинж:

Охины дүрийг сонгосон бол дотоод шинж:



4

Сурагчийн овог, нэр: .....

Эхэлсэн .. он .. сар... өдөр ...цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

**СЭДЭВ:** Эсрэг ба ойролцоо утгатай зэрэгцсэн нийлмэл үгийн утга, үүрэг**АГУУЛГЫН ТОВЧ ТАЙЛБАР:****Эсрэг утгат үг:** Утгаараа харилцан эсрэгцсэн бүлэг үгийг хэлнэ. Эсрэг утгат үг нь оновчтой цөөн үгэнд гүн гүнзгий, их утгыг багтаахад найруулгын үүрэгтэй.**Ойролцоо утгат үг:** Дуудлага бичлэгээрээ өөр, утгаараа ойролцоо хийгээд тун адилхан үгсийг хэлнэ. Ойролцоо утгат үг нь өгүүлж байгаа санаандаа яв цав тохируулан сонгоход найруулгын үүрэгтэй.**Зэрэгцсэн нийлмэл үг:** Нэг үг нь нөгөө үгээ захирахгүй, тэгш эрхтэй холбогдож, утга, бүтэц, аялгын хувьд нэгдмэл болсон үгсийг хэлнэ.**Эсрэг ба ойролцоо утгатай зэрэгцсэн нийлмэл үгийн найруулгын үүрэг:**

- Нэгийн утга нөгөөгөө тэлж, санааны явцууг тэнийлгэх
- Утгыг илүү тод, олон талтай илэрхийлэх
- Найруулгыг тэгш хэмтэй, сонсоход ая дантай, яруу сайхан болгох

<https://econtent.edu.mn/> хаягаар дараах холбоосоор хичээл үзэж, “Ойролцоо утгатай зэрэгцсэн нийлмэл үгийн найруулгын утга, үүргийг тодорхойлох” талаар мэдэж аваад, дараах дасгал даалгаврыг хийгээрэй. (<https://econtent.edu.mn/lessons/EBS/7rangj/mon/654>)

**Дасгал 1.** Зэрэгцсэн нийлмэл үгийн утга, үүргийг тодруулъя.

- А.** 1 дүгээр цогцолборын **зэрэгцсэн нийлмэл үгийг** 2 дугаар цогцолборт **дан үг** болгон хувиргасныг анхааралтай харьцуулж уншъя.
- Б.** 1дүгээр цогцолборын **зэрэгцсэн нийлмэл үгийг** олж, доогуур нь зурж тэмдэглээрэй.
- В.** 1,2 дугаар цогцолборын алийг нь уншихад “Тэгш хэмтэй, сонсоход ая дантай, яруу сайхан” байна вэ?

Учир нь юу бол.....

1. Хүндрэл бэрхшээл, зовлон гуниг дутуу гуцуугийн зүдгүүр, тогтворгүй цагийн ааш араншинг сэтгэлийн хатаар даван туулж, ямар ч нөхцөлд, ямар ч үед “Хугараагүй ноён нуруутай” аж төрж, төрөлх хүн чанараа гээлгүй хүний хорвоог гийгүүлсээр утга төгөлдөр амьдрах сайн сайхан хүмүүс онцгой бахархам, олон түмэндээ үлгэртэй

2 Хүндрэл, зовлон, дутуугийн зүдгүүр, тогтворгүй цагийн аашийг сэтгэлийн хатаар давж, ямар ч нөхцөлд, ямар ч үед “хугараагүй ноён нуруутай” аж төрж, төрөлх хүн чанараа гээлгүй хүний хорвоог гийгүүлсээр утга төгөлдөр амьдрах сайн хүмүүс онцгой бахархам, түмэндээ үлгэртэй.

**Г.** Дан үг, зэрэгцсэн нийлмэл үгийн аль нь өгүүлбэрт “Илүү тод, олон талт утга илэрхийлж байна вэ? гэдгийг тайлбарлая.

**Нэг үгийг хамтдаа тайлбарлая.** Үүний тулд үгийн утгыг толь бичгээс харъя.

“Хүндрэл бэрхшээл” – Үг тус бүрийн утгыг тайлбар толиос харъя. “Хүндрэл”- Нөхцөл байдал хэцүү болох, “Бэрхшээл”- ахуй амьдрал, ажил хэрэг, аян замд тохиолдох саад тотгор.

**Тайлбар:** “Хүндрэл”- гэсэн үгийг дангаар хэрэглэвэл дээрх нэг л утга илэрхийлэх бол зэрэгцүүлэн хэрэглэснээр хоёр үгийн утга хоршиж, илүү тод, олон талт утгыг илэрхийлж байна.

Тайлбарлах үгс:

1. Зовлон гуниг: .....
2. Ааш араншин .....

**Дасгал 2.** Зэрэгцсэн нийлмэл үгийн утга, үүргийг тодруулъя.

**А.** Дараах эсрэг утгат зэрэгцсэн нийлмэл үгээр өгүүлбэр зохиоё.

**Б.** Эсрэг утгат зэрэгцсэн нийлмэл үг нь “Оновчтой цөөн үгэнд гүн гүнзгий, их утгыг багтааж” байна гэдгийг тайлбарлая.

**Хамтдаа нэг үг тайлбарлаж, өгүүлбэр бүтээе.**

**А.** Чоно хонь хоёр шиг нэгнээ үздэггүй байсан тэд ойлголцсон нь юутай сайхан.

**Б.** “Чоно хонь хоёр шиг” Тус эсрэг утгат хэлцээр бие биеэ үзэж чаддаггүй, эв нэгдэлгүй, дайсагналцах, хоорондоо зөрчилтэй гэх мэт дэлгэр санааг илэрхийлжээ.

**Жишээ үгс:**

**Үг:** Эх адаггүй ажил:

Өгүүлбэр: .....

Тайлбар: .....

**Үг:** Цаана наана гарах

Өгүүлбэр: .....

Тайлбар: .....

**В.** Дараах хэсгийн цэгийн оронд дор өгсөн ойролцоо утгат үгээс аль тохирохыг нөхөж бичиж, өгүүлбэрийг гүйцээе.

- Чадал хүчээр.....тул яагаад ч өргөж даасангүй. ....номхон хүнийг дарлах хүн олон байдаг. ....хөгжилтэй оронд туслах болов.
- Баруун хашаанд нь нэгэн .....эр сууна. Манай дэлгүүрээс хар нөмрөгтэй нэг .....авгай өдөр бүр сүү авдаг байв.
- Эхнэр хүүхэд ч үгүй эр бие .....амьдарна. ....хүн өөнтөгч гэж тэр их адайр болжээ.

**Нөхөх үгс:** буурай, **дорой**, Мөхөс, өнчин, ганц бие, гоонь, ганцаар

**Г.** Эхээс ойролцоо утгат зэрэгцсэн нийлмэл үгийг олж, тэмдэглэ. Найзаа сонгон, ойролцоо утгат зэрэгцсэн нийлмэл үгийг ашиглан товч тодорхойлж бичээд, найруулгыг сайжруулъя.

**Эх:** Миний өвөө хүдэр чийрэг хүн байлаа. Тэр өндөр цэх нуруутай, бас тайван амгалан, шударга үнэнч хүн байсан. Цэгц шулуун алхаатай өвөөг харахад л түүний хүч тэнхээ мэдрэгдэх ба түүний хүнлэг өгөөмөр занг ч хүн бүхэн анзаардаг байв.

No : \_\_\_\_\_ Date : \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

5


Сурагчийн овог, нэр: .....

Эхэлсэн .. он .. сар... өдөр ...цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

**СЭДЭВ:** Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн утга, үүрэг**АГУУЛГЫН ТОВЧ ТАЙЛБАР****Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр:** Үйл явдлууд бие биеэсээ үл шалтгаалан нэг цагт зэрэг болохыг илтгэсэн өгүүлбэрүүдийг зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр гэнэ.

ЗНӨ = бүтэц өгүүлбэр + бүтэц өгүүлбэр

**Дасгал 1. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн найруулгын үүргийг тайлбарлая.****А. Хамтран нэгэн өгүүлбэрийг задлан тайлбарлая. Анхааралтай, ойлгож уншъя.****Өгүүлбэр нь:**

- Нямсүрэн усан дээр хээ татмаар илбүүрдэж, Дашбалбар аархан хурц ухаан номуун билгээр агсам тавьж, Мэнд-ооёо намуухан хэрнээ алтан цутгалангаар урсаж, Чимэддорж хөдөөгийн хөх өвсөнд ороолдож явсан.

1. Нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэрээр зааглая. Энгийн өгүүлбэр гэж нэг үйл явдлыг хэлнэ.

- Нямсүрэн усан дээр хээ татмаар илбүүрдэж,
- Дашбалбар хурц ухаан номуун билгээр урлаж,
- Мэнд-ооёо намуухан хэрнээ алтан цутгалангаар урсаж,
- Чимэддорж хөдөөгийн хөх өвсөнд ороолдож явсан. (4 энгийн өгүүлбэр)

**Дүгнэх нь:** Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр нь 2 ба түүнээс дээш энгийн өгүүлбэрээс бүтнэ.

2. Энгийн өгүүлбэрийн үйл, үйлийн эзнийг олъё. Дээрх өгүүлбэрт өнгөөр тэмдэглэе.

**Дүгнэх нь:** Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн үйл бүр эзэнтэй байдаг.

3. Энгийн өгүүлбэрийн өгүүлэхүүний нөхцөлийг өнгөөр тэмдэглэж, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр нь ямар нөхцөлөөр холбогддогийг мэдье. (шар өнгөөр)

**Дүгнэх нь:** Үйлийн зэрэгцүүлэн холбох нөхцөл -ж, -ч, -н, -аад<sup>4</sup> холбогдоно.

4. Дээрх 4 энгийн өгүүлбэр нь утгын хувьд зэрэгцэж байгааг баталъя.

Үүний тулд энгийн өгүүлбэрүүдийн байрыг солиход, утгад өөрчлөлт гарах эсэхийг харъя.

- Мэнд-ооёо намуухан хэрнээ алтан цутгалангаар урсаж,
- Нямсүрэн усан дээр хээ татмаар илбүүрдэж,
- Дашбалбар хурц ухаан номуун билгээр урлаж,
- Чимэддорж хөдөөгийн хөх өвсөнд ороолдож явсан. (4 ийн өгүүлбэр)

**Дүгнэх нь:** Энгийн өгүүлбэрүүдийн байрыг солиход нийлмэл өгүүлбэрийн утгад өөрчлөлт гарахгүй байна. Эндээс харахад энгийн өгүүлбэрүүд нь дараах шинжтэй байна  
Үүнд:

- Үйл явдал нь нэг цагт зэрэгцэж болж байна.
- Өгүүлбэрүүд нь бие биедээ захирагдахгүй тэгш эрхтэй байна.

**Б.** Дээр тайлбарласны дагуу дараах өгүүлбэрийг задлан тайлбарлая.

**Өгүүлбэр нь:** Баян Болдын нас нь дөчөөд, толгой нь халзан, гэдэс нь бүдүүн, сахал нь битүү, нүд нь улбар, зан нь төв.

Баян Болдын

нас нь дөчөөд

1. Хэдэн энгийн өгүүлбэр байна вэ? А.7 Б.6. В.9

толгой нь халзан

2. Энгийн өгүүлбэрээс үйл, үйлийн эзнийг олъя.  
Жишээ нь: “Нас нь дөчөөд” гэсэн энгийн өгүүлбэрийн дөчөөд” гэсэн тооны нэр үйлшиж, үйлийн үүрэг гүйцэтгэж байгаа бол, эзэн нь “нас нь” гэсэн үг болно.  
Үйл бүр эзэнтэй байна уу? .....

гэдэс нь бүдүүн

сахал нь битүү

3. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрүүдийн холбогдох нэг арга нь хэлэх аялга юм. Энэ нь өгүүлбэрүүд хоорондоо нөхцөлгүй холбогдох арга юм. (Өмнөх дүрмийг хараарай.)  
Тэгвэл эдгээр өгүүлбэрүүд ямар аргаар холбогдсон байна вэ?  
.....

нүд нь улбар

зан нь төв.

4. Энгийн өгүүлбэр нь утгын хувьд зэрэгцэж байгааг баталъя. Үүний тулд Энгийн өгүүлбэрүүдийн байрыг солиход нийлмэл өгүүлбэрийн утгад өөрчлөлт гарах уу?  
.....

**В.** Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр нь 3 аргаар холбогддог. Дээрх хоёр аргыг тайлбарлан ярилцлаа. Дараах өгүүлбэр ямар аргаар холбогдсоныг өмнөх дүрмээс хараарай.

**Өгүүлбэр нь:** Дэжидийн нас нь 40 орчим бөгөөд зан ааш нь хурдан, үг хэл нь ширүүн.

1. ....
2. ....
3. ....
4. ....

**Г.** Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн найруулгын үүргийг өмнөх өгүүлбэрүүдээс сонгон, жишээлэн тайлбарлаж бичье.

**ЗНӨ-ийн найруулгын үүрэг:**

- Хүн юм үзэгдлийн гадаад төрх байдал, дотоод мөн чанар, үйл хөдлөл, бодит байдлыг тодорхой нэгэн цагт зэрэгцүүлэн тоочиж дүрслэх
- Найруулгад тэгш хэм бүтээх үүрэгтэй.

.....  
.....  
.....  
.....

6

Сурагчийн овог, нэр: .....

Эхэлсэн .. он .. сар... өдөр ...цаг

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

**СЭДЭВ:** Гадаад дотоод шинжийг тоочин дүрсэлж бичих

<https://econtent.edu.mn/> хаягаар дараах холбоосоор хичээл үзэж, “Сонин содон үг хэллэг, тэмдэг нэр, мэдрэмж сэтгэгдэл оруулан, гадаад дотоод шинжийг тоочин дүрсэлж хөрөг бичих “ талаар мэдэж аваад, дараах дасгал даалгаврыг хийгээрэй.

<https://econtent.edu.mn/lessons/EBS/7rangi/mon/3581>

Бид тоочин дүрслэх арга хэрэглүүрийг мэдэж авсан.

Түүнийгээ ашиглаад тоочин дүрслж бичье.

Тэмдэг нэр

Тоочих найруулга:  
Зэрэгцсэн нийлмэл үг,  
Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр

Уран дүрслэл

**Дасгал 2:** Эхийг анхааралтай уншаад, тоочин дүрсэлсэн эх болохыг баталъя.

А. Эхийн өгүүлбэрүүдийг зэрэгцүүлэн холбохын ямар аргаар холбосон байна вэ?

.....

Б. Эхэд тэмдэг нэр, уран дүрслэл нь ямар утга, үүргээр орсон байна вэ?

.....

В. Тоочин дүрсэлсэн эх гэдгийг чи ямар шинжээр нь батлах вэ?

.....

Г. Чи гадаад дотоод шинжийг тоочин бичих ямар аргыг сурсан бэ?

.....

Би найз Сараагийнхаа тухай ярьж. Бид 1 дүгээр ангиасаа хойш найзалж, бүр нэг ширээнд сууж байсан.

Сараагийн царай гоо үзэсгэлэнтэй бөгөөд магнай нь бага зэрэг гүдгэр. Түүний арьс цагаан цайвар, хацар нь гэрэлтэж харагддаг. Хөмсөг нь хар, дугуйвтар. Хамар нь жижиг, шулуун, шантгардуу. Тэр инээхдээ хамраа үрчийлгэх нь түүнийг эгдүүтэй харагдуулдаг. Инээмсэглэхэд түүний хацар дээр хөөрхөн хонхорхой тодрох бөгөөд түүний инээх нь тунгалаг, хөгжилтэй.

Нүд нь янзаганы нүд шиг сэрвэгэр, бор, сормуус нь урт өтгөн. Нүдний харц нь үргэлж найрсаг, зөөлөн байдаг. Гэхдээ хааяа уурлахад нь нүд нь ширүүн хурц болдог. Тэр хааяа нүдээ онийлгож бодолхийлдэг. Уруул нь ягаан, шүд нь хаш шиг цагаан, чих нь жижиг. Тэр зүрхэн хэлбэртэй мөнгөн ээмэг зүүх дуртай.

Миний найзын үс нь бараан, долгионтой бөгөөд үсээ ихэнхдээ шууж, хөөрхөн зүүлт зүүдэг ба хааяа хоёр сүлжсэн нь эгдүүтэй харагддаг.

Сараа намхавтар нуруутай, урт, нарийхан хүзүүтэй. Энэ нь үсээ боосон байхад нь бүр тод мэдрэгддэг. Тэр төгөлдөр хуур тоглодог бөгөөд шулуун урт хуруутай. Найз маань цэвэрхэн, сайхан хувцасладаг. Тод өнгийн даашинз өмсөх дуртай.

Тэр мэддэг чаддагаа бусадтай хуваалцах дуртай, бусдад чин сэтгэлээс тусалдаг, ном: унших, театр, музейд очих дуртай. Миний дотны найз хөгжилтэй, ухаалаг, найз нөхөд нь түүнийг хүндэлдэг, ямар ч нөхцөлд гэрэл гэгээтэй талыг хардаг нь надад таалагддаг.

Миний найз бол миний мэдэх хамгийн гайхалтай охин.

Эхлэл  
“Танилцуулга”

Гол  
“Гадаад дотоод  
шинж”

Төгсгөл  
“Дүгнэлт”

**Дасгал 2:** Өөрийн хайртай хүүхэлдэйн киноны баатрыг сонгон, гадаад дотоод шинжийг тоочин дүрсэлж бичье.

- А.** Гадаад, дотоод шинжид тохирох тэмдэг нэр, дүрслэх ур маягийг баатрынхаа хажууд тоочин бичье.
- Б.** Тэдгээр үгсээ ашиглан, баатраа дүрслэн тоочиж бичье.
- В.** Эхийн найруулга болон зөв бичих дүрмээ дахин дахин сайжруулаарай.

## ШИНЖ БАЙДАЛ

### ГАДААД

Гаднаас харъя:

- Биеийн төрх:.....
- .....
- Хувцаслалт:.....
- .....
- Дохио зангаа: .....
- .....
- Алхаа гишгээ: .....
- .....



### ДОТООД

Дотроос нь харъя.

- Ааш зан:.....
- .....
- Яриа хөөрөө: .....
- .....
- Давтагдашгүй чанар: .....
- .....
- Бодол санаа: .....
- .....

**Дүгнэлт:** Гадаад дотоод шинжээс үндэслэн дүрээ дүгнээрэй. (Бахархсан, гайхсан, хайрласан, өхөөрдсөн зэргээр үнэлэмж хандлагаа илэрхийлье.)

**Үгийн нөөцөд:**

Дунд зэргийн нуруу, ясархаг туранхай, хацар нь хонхор, шанаа нь өргөн, хөмсөг нь өтгөн, нүд нь хурц, боровтор, ширүүн дориун, намуун тайван, ой ухаан саруул, яриа хөөрөө тод, ухаан сийрэг, цэгц шударга, хар ухаан бор бодолтой, сайхан тулхтай, шударга яриа хөөрөөтэй, шударга цэгц, цайвар, зөөлөн царайтай, хацарт нь улаан туяа туссан, туранхай хатингар биетэй.

Шинэ сарны адил хурц тунгалаг царай, төрсөн нь саран мэт сайхан, цэцэг адил үзэсгэлэн, солонго мэт өнгөтэй, хас адил ариун. ...

Тавлаад суухаараа Тавин хоёр хүний зайд суудаг. Тахийгаад суухаараа Хорин таван хүний зайд суудаг баатар...

**Дасгал 3.** Дүрийнхээ гадаад дотоод шинжийг тэмдэг нэр, дүрслэх ур маяг ашиглан, сэтгэлд бууж, нүдэнд харагдтал тоочин дүрсэлж бичье. (Эхийг дэвтэртээ бичье.)

- Сэдэв буюу хэний тухай бичихээ сонгоё. Өөрийн сайн мэдэх хүнээ сонгоё..
- Бичих зүйлээ төлөвлөж, арга хэлбэрийг сонгоё

Эхлэл	<p><b>Яаж эхлэх вэ?</b>          Дүрээ сонгосон учраа тайлбарлаж эхлэх үү?          Ямар нэгэн хөгжилтэй товч түүхээр эхлэх үү?          Асуултаар эхлэх үү?          Түүний талаар бусдын хэлсэн сайхан үгээр эхлэх үү?          Дүрээ танилцуулж эхлэх үү?</p>	<p>Яаж бичих вэ?</p> <p>Тоочин дүрслэх арга хэрэглүүр</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тэмдэг нэр</li> <li>• Уран дүрслэл</li> <li>• Тоочин дүрслэх</li> </ul> <p>(Зэрэгцсэн нийлмэл үг, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр)</p> <p>Тухайн дүрийн онцлогийг харуулахуйц үг хэллэгээ сонгоно.</p>
Гол	<p><b>Гадаад, дотоод шинжийг бичих үү?</b> Хүний зан чанар, дотоод сэтгэл, гадаад үзэмж хийгээд өрөөл бусдаас ялгагдах хамгийн онцлог шинжийг тодотгох</p> <ul style="list-style-type: none"> <li>• Гадаад шинжид юуг юуг дүрслэх вэ?</li> <li>• Дотоод шинжид юуг юуг дүрслэх вэ?</li> </ul>	
Төгсгөл	<p><b>Яаж төгсгөх вэ?</b>          Дүрээсээ нээсэн сайн сайхан зан чанарыг дүгнэж үү?          Түүний талаар бусдын хэлсэн сайхан үгээр үү?          Ирээдүйг нь зөгнөсөн сайн сайхан ерөөлөөр үү?</p>	

- Ноороглон бичье) (Бичиж сурах чухал алхам тул сайн дадаарай)
- Цаасныхаа дээд талд сэдвээ бичнэ.
- Тухайн эхээр гаргах гол санаагаа 1-2 өгүүлбэрээр илэрхийлж бичээд, доогуур нь зурна. Ингэснээрээ эхийнхээ гол санааг үргэлж санана.
- Цаасныхаа мөрийн хооронд 1-2 мөр бичих зай, цаасныхаа 2 талд мөн зай үлдээнэ. Бичсэнээ сайжруулахын тулд эдгээр зайнд шаардлагатай баримт жишээг дараа нь нэмж бичнэ.
- Төлөвлөгөөний дагуу эхний нооргоо бичээрэй. Сэдэвтэй холбоотой баримт, жишээ, үзэл бодлоо багтааж, тасралтгүй бичихийг хичээ. Төлөвлөгөөнд байхгүй санааг нэмэх хэрэггүй.
- Эхний ноорог төгс байх шаардлагагүй тул цэг тэмдэг, үг үсгийн алдаанд санаа зоволгүй төлөвлөгөөий дагуу аль болох их бичих хэрэгтэй. Бичих явцдаа санаагаа бүрэн гаргаж чадахгүй бол зай орхиод дараа нь нехөж бичиж болно.
- Бичих явцад өөр шинэ, чухал санаа төрвөл мартаггүйн тулд даруй цаасныхаа хажуу талын зайнд тухайн хэсгийн харалдаа тэмдэглэж авна.

Өөрийгөө үнэлъе.

	Асуулт	Өөрийн үнэлгээ		
		+++	++	+
1	Эхлэл, гол төгсгөл хэсгийг гаргасан уу?			
2	Дүрийнхээ гадаад дотоод онцлог шинжийг сэтгэлдээ хүртэл дүрмэлж чадсан уу?			
3	Тэмдэг нэр ашигласан уу?			
4	Уран дүрслэл ашигласан уу?			
5	Найруулгын болоод зөв бичих дүрмийн алдаагүй юу?			



**7** Сурагчийн овог, нэр: .....  
 Эхэлсэн .. он .. сар... өдөр ...цаг  
 Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

**СЭДЭВ:** Зөв бичье.

**Дасгал 1**

“эгшиг+т, цацаг+т, цэцэг+т” хэмээх үгсэд холбогдох зөв бичих дүрмийг олж, тайлбарлая.

1. Эгшигт гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч эгшиггүй орж болно.
2. Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгчийг эгшигтэй бичнэ.
3. Эгшигт гийгүүлэгчийг ямагт эгшигтэй бичнэ.

**Дасгал 2** Дараах язгуур, үндсэнд зохих залгавруудыг залгаж бичээд хэсэг тус бүрийн холбогдох зөв бичих дүрмийг тайлбарлана уу?

**А.** Язгуур үндсэнд залгаврыг залгаж бичье

- а. Бодол+ оос, тараг+ийг, хамар+ыг .....
- б. Тайлбар+аас, бөмбөг+өөр, тэнгэр+ийн .....
- в. Бич+г, сур+г, бос+ж .....
- г. Хөл+д, сүүл+д, түмэн+д .....
- д. Тус+д, бос+ж, ид+ш .....
- е. Үз+сэн+ээс, ач+тан+ыг, нөх+цөл+өөр .....

**Б.** Үг тус бүрийн холбогдох дүрмийг тайлбарлая.

.....  
 .....  
 .....

**Дасгал 3** Дараах үгсээс зөв бичих зүйн үүднээс ялгаатай үгийг олж, ялгаатай байгаагийн учрыг тайлбарлая.

**А.** Ялгаатай үгийг олж доогуур нь зуръя.

Жишээ үгс: Хувцас+л, үндэс+л, харагд+на, ярилц+на, авир+ на

**Б.** Ялгааг нь тайлбарлая.

1. Заримдгаар төгссөн үгэнд ардаа эгшиггүй заримдгаар эхэлсэн залгавар ( дагавар нөхцөл) залгахад эгшиг жийрэглэнэ.
2. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд ардаа эгшиггүй эгшигт гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгавал эгшиг жийрэглэнэ.
3. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд ардаа эгшиггүй заримдгаар гийгүүлэгчээр эхэлсэн дагаврыг шууд залгана.

**Дасгал 4** Дараах тулгуур дохиог ажиглаад, зөөлний тэмдэг “И” болох, зөөлний тэмдэг “И” болохгүй дүрмийг тайлбарлана уу?

**А** Жишээ хувиллаас “Ь” - “И” болох дүрмээ ойлгож бичье.

барь, харь, соль	<b>Ь</b> + эгшиг =	бариул, хариад, солиод		.....
захь, зохь, дохь	9Ь+9=	захидал, зохисон, дохиж		.....
захь, зохь, дохь	9Ь+7=	захилаа, зохино, дохив		.....
барь, харь, тань	7Ь+7=	барилаа, харина, танив		.....

**Б.** Жишээ хувиллаас “Ь”-“И” болохгүй дүрмээ ойлгож бичье..

<b>7Ь+9= Ъ</b>	барьдаг, харьсан, тарьж	.....
<b>Гажилт:</b>		.....
✓ х-ийн өмнө	барих, харих, таних	.....
✓ ь тэмдгээр төгссөн үгэнд	барья, танья, больё	.....
✓ ь+ гүй = Ъ	аалыгүй, хоньгүй, ханьгүй, морьгүй	.....
✓ Оноосон нэр-ь	Дарьбазар, Байгальмаа	.....

**Дасгал 5** “Шагначихлаа, гагнасны , эмхэтгэл, бэлтгээрэй, суугаад” үгсийг ажиглаад, ямар ямар дүрэмд захирагдаж зөв бичихийг тайлбарлая.

**Дасгал 6** Дараах өгүүлбэрээс тэмдэглэсэн үгсийг бүтцээр задалж зөв бичих дүрмийг тайлбарлая. Утгыг нь мэдэж авъя..

Алхам 1 Онцолсон үгсийг бүтцээр задлаарай.

1. Муу муудаа *дээрэлхүү* Муна гадсандаа *дээрэлхүү* .....
2. Бясалгал нь сэтгэлээ *номхотгох арга юм* .....
3. *Нэрэлхүү* хүнд хоолгүй, нарийн хүнд нөхөргүй .....
4. *Үнэхээр* сайхан санаа байна. ....
5. Хаалгаа хаагаарай гэх дуу сонсогдов. ....
6. *Хүүгийн* морь уяан дээр *үүрсэж* байна. ....

Алхам 2 Зөв бичих дүрмийг тайлбарлаж бичээрэй.

**Дасгал 7** “Н гийгүүлэгчээр төгссөн голдуу тэмдэг нэр үндэс (язгуур)-д үйл бүтээх зарим дагавар залгахад эцсийн Н гийгүүлэгч гээгдэнэ” гэдэг зөв бичих дүрэмд тохирох жишээ 3-аас доошгүйг олж бич.

**Дасгал 8** Жишээг уншиж, дүрэмтэй нь харгалзуулъя.

- |  |  |
|--|--|
| А. Сулд+га, бэлд+гэ,<br>цомход+го, эмхэд+гэ,<br>батад+га, номход+го        | 1. И-гээс бусад богино эгшгээр төгссөн үндэс (язгуур)-д урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад сүүлийн богино эгшиг гээгдэнэ.                                 |
| Б. Хар+р, бор+р,<br>сүр+рх, дээр+рх, эр+рх,<br>нэр+рх                      | 2. Урт, хос эгшгээр төгссөн үндэс (язгуур)-д урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад Н,Г гийгүүлэгчийн аль нэгийг жийрэглэнэ                                   |
| В. Торго+ыг,<br>сурга+ууль, бэлтгэ+<br>үүл, өргө+үүл, үнэ+ээр,<br>сана+аад | 3. Д гийгүүлэгчээр төгссөн үйл үндсэнд үйлдүүлэх хэвийн –ГА (-ГЭ,- ГО,- ГӨ) дагавар залгахад Д гийгүүлэгч Т болж ондоошно.                                   |
| В. суу+аад, дуу+аас,<br>хаа+аарай, хүү+ийн,<br>нохой+оор, сүү+ээс          | 4. Р гийгүүлэгчтэй (голдуу Р гийгүүлэгчээр төгссөн) үндэс (язгуур)-ийн араас Р гийгүүлэгчээр эхэлсэн дагавар залгахад дагаврын Р гийгүүлэгч Л болж ондоошно. |

**Дасгал 9** я,е,ё -г залган бичих дүрмийн мэдлэгээ шалгая.

А. Загварт өгсөн дүрмийг жишээтэй нь зөв харгалзуулаарай.

1. Эгшгээр төгссөн үгэнд + я,е,ё = **ШУУД**  
Я,е,ё төгссөн үгэнд + я,е,ё = **ШУУД**
2. Гийгүүлэгчээр төгссөн эр үгэнд + я,ё = **Ъ**
3. Гийгүүлэгчээр төгссөн эм үгэнд + е = **Ь**

- А. Бодъё, суръя, харъя,
- Б. бууя, гүйе, хүргэе – уяя, хаяя, оёё
- В. бичье, үзье, хэлье, дүүлье

**Б** Дүрэм тохирох 5.5 жишээ бичээрэй.

- А. Эгшгээр төгссөн үгэнд +я,е,ё= шууд .....
- Б. Гийгүүлэгчээр төгссөн эр үгэнд +я,ё= Ъ .....
- В. Гийгүүлэгчээр төгссөн эм үгэнд +е= Ь .....
- Г. Я,е,ё төгссөн үгэнд +я,е,ё= ШУУД .....



**Тоочин дүрсэлсэн эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилье.**

Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр



Бид өмнөх дасгал ажлын дэвтрийн даалгаврыг гүйцэтгэх явцад “Хүний гадаад, дотоод шинжийг тоочин дүрслэх” талаар ойлголттой болсон.

Харин энэ удаа “Үйл хөдлөлийг тоочин дүрсэлсэн” эхийг задлан шинжилж, тоочин дүрслэх чадвараа улам хөгжүүлцгээе.

**ДАСГАЛ 1.** Тоочин дүрсэлсэн эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилье.

**Алхам 1.** Эхийг бүтцээр задалсныг анхааралтай уншаад, асуултад хариулж бичье.

**Зун**

Цагийн улирал зуны дундад хүрч, тунгалаг наран өндөр мандаад, түмэн бодисын хөгжин дэлгэрэхийг баясан толилуулахуйяа

**Эхийн эхлэл хэсэгт** хэний, юуны тухай тоочин дүрслэх вэ? гэдгээ танилцуулдаг. Тэгвэл энэ эхийн эхлэл хэсэгт юуны тухай танилцуулсан байна вэ?

.....

.....

байгалийн доторх бодис бүр биелэн цогцолж мод навчлан, цэцэг жигдэрч, уул хөхрөн, тал ногоорч, гол угалзлан, горхи сүлжилдэж, булаг оргилон, нуур мэлтэгнэж, бургас намилзан, бут бурзайж, хуш хуурдан, улиас ухилж, хайлс инээн, хад өнгийж, нарс найган, монос ганхаж, үнэхээр хөгжимгүй атал эгшиглэх адил, хүнгүй атал дуулах мэт өөртөө яруугаар дуурсах бөгөөд ойд нуугдагч хөхөө донгодон, буга урамдаж зүг бүрээс ирсэн зүйл бүрийн шувууд агаарт халин нисээд, нууранд хөвөн умбаад, модыг хэсэн, мөчрийг дамжин донгодон бүжиглэж наадна.

**Эхийн гол хэсэг** хоёр цогцолбороос бүтжээ. Тус бүрд юуны тухай тоочин дүрсэлсэн байна вэ? Эхний цогцолборт:

.....

.....

...Ийм нэгэн жаргалтай дэлгэр, хөгжилтэй сайхан зуны улиралд саруул сэргэлэн, дэлгэр сайхан талбай нутагт айл өрхөд хот саахалтаар салбарлан буудаллаж, тэрэг чингэлэг угсраад, унага тугал зэллэж, идээ цагаа дэлгэрээд, хурга ишиг, хүүхэд багачууд нь гадуур орчимдоо бужигналдан, энд ч айраг исгэж, тэнд ч архи нэрээд, Даваа даага сургаж, Бадам бяслаг шахан, Дулмаа үнээ сааж, Дугар тэрэг засан, адуу хонийг ээлжээр хариулан, аян жинд хамтран явцгааж,

Хоёрдугаар цогцолборт:

.....

.....

төрсөн нутагтаа өвөлд нь өнтэй, зунд нь хуртай үнэхээр дэлгэр ажгуу. (М.Ядамсүрэн)

**Эхийн төгсгөл хэсэгт** эхлэл, гол хэсгийг хэрхэн дүгнэснийг ажигла.

**Алхам 2.** Өгүүлбэрийг гүйцээж, эхийн хэсгүүдийн уялдаа холбоог дүгнэж бичнэ үү.

Эхлэл хэсэгт .....танилцуулсан бол, гол хэсгийн эхний цогцолборт .....тухай, харин хоёрдугаар цогцолборт .....тухай тоочин дүрсэлж, төгсгөлд нь өмнөх хэсгүүдийн санааг нэгтгэн дүгнэсэн байна.

Тоочин дүрсэлсэн эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилье.

Алхам 3: Эхийн түлхүүр үг, өгүүлбэрээс сэдэв, гол санааг тодорхойлъё.

Түлхүүр үг:

Тухайн эхийн утга, агуулгыг гаргахад чухал үүрэгтэй, олон давтагдаж орсон үгийг хэлнэ.

Эхлэл хэсэгт: Цагийн улирал **зуны** дундад хүрч...

Гол хэсэгт: ...хөгжилтэй сайхан **зуны** улиралд...

Төгсгөл хэсэгт: ... **зунд нь** хуртай...

Эхийн сэдвийг тодорхойлж бичээрэй.  
.....  
.....  
.....

Түлхүүр өгүүлбэр:

Тухайн эхийн цогцолбор бүрийн гол утгыг мэдээлж байгаа өгүүлбэрийг хэлнэ.

1 дүгээр цогцолбор:

...үнэхээр хөгжимгүй атал эгшиглэх адил, хүнгүй атал дуулах мэт.

2 дугаар цогцолбор:

... төрсөн нутагтаа өвөлд нь өнтэй, зунд нь хуртай үнэхээр дэлгэр ажгуу.

Түлхүүр өгүүлбэрүүдийн санааг харьцуулан эхийн гол санааг зөв тодорхойлсон хэсгийг дугуйлаарай.

- А. Зун байгаль дэлхий сайхан байдаг.
- Б. Зун хүний амьдрал жаргалтай байдаг.
- В. Байгаль дэлхий сайхан бол хүний амьдрал жаргалтай дэлгэр байдаг.

Алхам 4: “Эхийн гол хэсэг”-ийг анхааралтай уншаад, “Эхийн эхлэл хэсэг”, “Эхийн төгсгөл хэсэг”- ийг гүйцээж бичээрэй. Агуулгын уялдаа холбоог анхаараарай.

Эхлэл хэсэг:

.....  
.....  
.....  
.....

Гол хэсэг:

Өглөөний нарны туяа элсний өнгийг улам тодруулан гялтгануулна. Салхиар зурагдсан элсэн хээ уран зургийг санагдуулна. Тэмээдийг харахад говийн жинхэнэ дүр төрх энэ л болов уу гэлтэй. Зэрэглээ хөвсөн говьд царцаа дэвхрэг нь шаргина. Элсний нарийн ширхэг, шаргалтсан тослог өнгө нь сэтгэл булаана. Элс нь салхиар нуран гулсахдаа онгоц мэт хүнгэнэн дуугарна. Манхны орой дээр гарахад цааш хэдэн зуун манхан толгод үргэлжлэн харагдана.

Төгсгөл хэсэг:

.....  
.....  
.....  
.....

Алхам 5. Асуултад хариулж бичье.

Гүйцээсэн эхийн бүтцийн хэсгүүд ямар сэдвээр холбогдож байна вэ?

.....  
.....  
.....

Хүүхдүүд ээ, Эх зохион бичихдээ эхийн бүтцийн хэсгийг агуулгын уялдаа холбоотой илэрхийлэхэд анхаараарай.

### Үйл хөдлөлийг ТООЧИХ аргаас суралцъя.

Сурагчийн нэр: .....

Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр



“Тоочих” гэсэн үгийн утгыг мэдье.


Юу болсон ба юу болж байгааг нэгд нэгэнгүй өгүүлэхийг тоочих гэнэ.

“Тоочсон эх”-ийн онцлог: Үйл явдлыг үзүүлэхдээ тухайн орны хүрээнд хэлний нэгжүүдийг зэрэгцүүлдэг.


#### ДАСГАЛ 2 Үйл хөдлөлийг тоочих аргыг задлан шинжилье.

Алхам 1: Хоёр загварыг анхааралтай харьцуулж ажиглаад, дүгнэж бичье.

А. Цогцолборт хүний гадаад, дотоод шинжийг тоочжээ.



Б.Цогцолборт үйл хөдлөлийг тоочжээ.



Хоёр загварыг харьцуулан дүгнэж бичээрэй.

Миний бодлоор төстэй тал нь:

Миний бодлоор ялгаатай тал нь:



Дараах алхмын дагуу асуултад хариулаарай.

Алхам	Даалгавар	Асуултад хариулаарай.
3	“Алхам 2”-ын энгийн өгүүлбэрүүдийн үйлийн нөхцөлийг ажиглаад, ижил нөхцөлийг нэг өнгөөр будъя.	<ul style="list-style-type: none"> <li>• цэцэг жигдэрч,</li> <li>• уул хөхрө,</li> <li>• нисээд.</li> </ul> <p>Зэрэгцэн болж байгаа үйл явдлуудыг ямар нөхцөлөөр холбох вэ?</p>
4	Нөхцөлүүдийг өнгөөр ялгаж дуусаад, энгийн өгүүлбэрүүд ямар ямар нөхцөлөөр холбогдсоныг ажиглаж, дараах дүгнэлтийг гүйцээж бичье.	<p>Энгийн өгүүлбэрүүд нь “....., ....., ....., ” гэсэн үйлийн зэрэгцүүлэн холбох нөхцөлөөр холбогдож байна.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
5	Эхээс сонгосон дөрвөн энгийн өгүүлбэрүүдийн байрыг сольё.	<p>Хариултаас сонгоорой.</p> <p>Үйлүүд бие биеэсээ хамааралгүй зэрэгцэн болж байгаа тул өгүүлбэрүүдийн байрыг солиход түүний утгад</p> <p>А. Өөрчлөлт гарна.</p> <p>Б. Өөрчлөлт гарахгүй.</p>
6	“Алхам 2”-ын энгийн өгүүлбэрүүдийн үйлийн эзний доогуур зураад асуултын хариултаас сонгоё.	<p>Хариултаас сонгоё..</p> <p>А. Үйл бүр эзэнтэй байна.</p> <p>Б. Зарим үйл эзэнтэй байна.</p>

Алхам 7. Өөрийнхөө эргэн тойронд болж буй 5 - 7 үйл хөдлөлийг зэрэгцүүлэн тоочоорой.

Бичсэнээ шалгая.  
Үйл хөдлөлийг тоочин бичих:

1. Энгийн өгүүлбэрүүдийг “-ж,ч”, “-н, ”, “-аад, -ээд, -оод, -өөд,” гэсэн үйлийн зэрэгцүүлэн холбох нөхцөлөөр холбосон уу.
2. Үйлүүд бие биеэсээ хамааралгүй зэрэгцэн болж байна уу?
3. Тоочсон үйл бүр эзэнтэй байна уу?



Үйл хөдлөлийг ТООЧИХ аргаас суралцъя.

Өмнө үзсэнээ сэргээн саная.

Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийг холбох хэрэглүүр

Үйлийн зэрэгцүүлэн холбох нөхцөл -ж, -ч, -н, -аад<sup>4</sup>

Тэнгэрт одод түгж, талд адуу бэлчинэ.

Хэлэх аялга

Цэн шувуу ирнэ. Цаст уул гэснэ. Цагаан шаргал гүү унагална.

Зэрэгцүүлэн холбох үгс ба, буюу, агаад, хийгээд, болон, болоод, бас, атал, нэг бол, эсвэл, мөн

Өвлийн хүйтнийг адуу манаж өнгөрүүлэх ба зуны халууныг хонь хариулж гэтэлгэнэ.

Алхам 8. “Үйл хөдлөлийг тоочсон” эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгэе.

- Эхийн эхлэл, төгсгөл хэсгийг өнгөөр будаж тэмдэглэ.
- Эхийг зэрэгцүүлэн холбосон аргыг дээрх хүснэгтээс харж тодорхойлж бичье.

.....



“Намар ай” - эхээс

Хөх хяруу хорголтсон зүс буурал өглөө. Намрын өглөө. Хөшөөтийн дөрөлжид хөх хондон бурхи нарлана. Хөх бүрлэн үнээ хэвтрээсээ өндийж хивдэсээ залгина. Ар хэцийн цас мөстөж талстлаад сондоршино. Алтан шарыг тунаруулсан уясуу өнгөөр уулс дүнсийнэ. Айл гэрүүд толгод дэнжид танантана. Шанд булгийн усан хүйтэн болроор тунгалагшина. Сайхан даа, сайхан намар цаг гэж өвгөд ярина. Хурсан хоньд үүлэн мөөг үүсгэнэ. Хулын хул зэрэглээ тэнгэр газрыг холбоно. Хулын хул зэрэглээнд зэсэн улаан тал буцална. Тугалын улаан хаданд тошлог иш дээрээ иснэ. Бөмбөрч унана. Уулс мөнгөн боронз мэт тунгалаг ширхгээр битүү түрхүүлж, усны нь эх зах цайртан хөлдөнө. Сонгинын цооргоно хөөмийлж исгэрнэ. Сонгинотын хөлд захчны тэмээд хэвтэнэ. Соёо бөхтэй хар ат солгон урттай зогдроо намиулж зогсоно. Тийм нэг ер бусын гоё хөндийд тэр гуай, энэ гуайнхан минь айлсана. Тэнгэрийн буян заяатай, улс даа энэ хөндийнхөн. (Б.Золбаяр)

Алхам 9. Эхийг хувиргаж бичье. “Зун” эхийн (Хуудас – 1) хэсгээс сонгон “Хэлэх аялга” - аар холбож найруулъя.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Алхам 10. “Намар ай” эхийг дуурайн 8 - 10 өгүүлбэрээр тоочин бичье. (Хавар, өвөл, зун) Бичихийн өмнө: Намрын улирлыг илэрхийлж байгаа гол үгсийг эхэд тэмдэглэ. Сонгосон улирлынхаа гол шинжийг илэрхийлэх үгсийг төлөвлө.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр



“Дүрслэх” – Үгийн утгыг мэдье.

1. Уран бүтээлд хүн, амьтан, юм үзэгдлийн хөгжил хөдөлгөөнийг үг хэл, үйл явдал, өнгөөр тусган илэрхийлэх. 2. Төсөөлөн бодох, ургуулан санах

Уран дүрслэл нь өгүүлж хэлэх санаагаа утга төгөлдөр, содон, сонирхолтой илэрхийлэх арга болдог тухай бид өмнө хичээлээр үзсэн.

**ДАСГАЛ 3.** Үйл хөдлөлийг тоочин дүрслэх аргаас мэдье.

**Алхам 1.** “Зун” эхээс сонгосон дараах өгүүлбэрээс үйл үг нь шууд бус утгатайг ялган, арын хүснэгтэд бичээрэй.

мод навчлан, уул хөхрөн,  
тал ногоорч, гол угалзлан,  
хуш хуурдан, улиас үхилж,  
хайлс инээн, хад өнгийж ...

**Алхам 2.** Асуултад хариулж, уран дүрслэлийг тайлбарлаж бичээрэй.

Яагаад “Гол угалзлан” гэж дүрсэлсэн юм бол?



1. Тайлбар толиос үгийн утга харъя.  
Угалз - Гоёмсог чимэг болгон хэрэглэх эргэлдсэн дугуй хэлбэртэй хээ  
Угалзлах – Тахиралдан мушгиралдах  
2. Дүрслэл яаж бүтсэн бэ?  
Голын тахиралдан урсах хэлбэрийг угалз хээтэй адилтгасан.  
3. Зохиолч энэ дүрслэлийг ямар учраас сонгосон бол?  
Голын голдирлыг нүдэнд харагдтал дүрслэх

Яагаад “Хуш хуурдан” гэж дүрсэлсэн юм бол?



1. Тайлбар толиос үгийн утга харъя.  
.....  
.....  
2. Дүрслэл яаж бүтсэн бэ?  
.....  
.....  
3. Зохиолч энэ дүрслэлийг ямар учраас сонгосон бол?  
.....  
.....

Алхам 3. Өгүүлбэрийн уран дүрслэлийг хувиргаж, эхийн санаанд ямар өөрчлөлт гарсныг тайлбарлая.

“Хайлаас инээн” гэснийг “Хайлаас уйлан” гэж сольё.



Тайлбар:

“Хайлаас инээн”, “Хайлаас уйлах” гэдэг нь аль аль нь хүншүүлэх аргаар бүтсэн байна. “Инээн” үйлийг “уйлах” гэсэн эсрэг утгаар сольсноор дүрслэлээс төрөх мэдрэмж сэтгэгдэл өөрчлөгдөж байна. Нартай хуртай сайхан өдөр ой моддыг инээж байгаагаар дүрсэлж болох бол хүний буруутай үйл ажиллагаанаас гэмтэж бэртэж, үхэж устаж байгаа моддыг хараад бид “уйлах” гэж дүрсэлж болно.

“Шувуу бүжиглэн”



Тайлбар:

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

Алхам 4. Зургийн үйл хөдлөлийг урнаар дүрсэлж өгүүлбэр зохионо уу. (Эхний эгнээнд хураангуй өгүүлбэр, дараагийн эгнээнд дэлгэрэнгүй өгүүлбэр зохиоё)



.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....



Хүн болон амьтад мэдрэхүйн таван эрхтнээрээ аливаа юмсын өнгө, дуу чимээ, үнэр, амтыг мэдэрч тухайн юмсыг танин мэддэг.

“Хүрэх, сонсох, амтлах, үнэрлэх, харах” –ыг үндсэн таван мэдрэхүй гэнэ.

**Алхам 5.** Өгүүлбэрүүдэд үйл хөдлөлийг таван мэдрэхүйн аль талаас дүрсэлснийг арын хүснэгттэй зураасаар холбож тэмдэглэнэ үү.

- Алтан шарыг тунаруулсан уясуу өнгөөр уулс дүнсийнэ.
- Вансэмбэрүү цэцгийн дэлбээ унаганы уруул шиг зөөлөн байлаа.
- Сонгинын цооргоно хөөмийлж исгэрнэ.
- Өглөөний тунгалаг агаарт хамар сэнхийнэ.
- Аадрын тэнгэр асга шаргитал нүргэлнэ.
- Арааны шүлс асгаруулам амттай байна.
- Тал нутгаас минь агь ганга ханхална.
- Нойтон цас бие жиндүүлнэ.
- Айл гэрүүд толгод дэнжид танантана.
- Санаа алдахад эхийн сүү тагнайд амтагдана.

	Харах
	Сонсох
	үнэрлэх
	амтлах
	хүрэх

**Алхам 6.** “Сургууль дээр”, “Цагаан сараар” гэх мэт сонирхсон сэдвээ сонгон, сэдвийн хүрээнд таван мэдрэхүйд юу юу өртдөгийг 10 өгүүлбэрээр тоочин дүрсэлж бичье.



1. ....
2. ....
3. ....
4. ....
5. Хүүхдүүд цовоо цолгин инээдээр халгина.
6. ....
7. ....
8. ....
9. ....
10. Сургуулиас минь эрдмийн гэгээ цацарна.

Сурагчийн нэр: .....

Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр




Дуу авиаг илэрхийлэх үгийг авиа дуурайх үг гэнэ.

Жишээ нь: тас няс, пад пад, жиг жуг, тар няр, сүр сар

Үйл хөдлөлийн шинжийг заасан үгийг дүрс дуурайх үг гэнэ.

Жишээ нь: хага хуга, бут бяц, гэдэн годон, өм цөм, там тум



**ДАСГАЛ 4.** Дүрслэх ба дуурайх үгийг найруулгад хэрэглэсэн учрыг тайлбарлая.

**Алхам 1.** Шүлгийг хэмнэлээр уншиж, дүрслэлийг сэтгэлдээ төсөөлөөрэй. Өгүүлбэрүүдийг үйлийн нөхцөлдүүлэн холбохын “-аад, -ээд, -оод” нөхцөлөөр зэрэгцүүлэн холбосныг ажигла.

Пионерийн зуслан	Сэрүүн салхи сэр сэр үлээгээд
Борооны дусал шивэр шивэр ороод	Сэтгэл зүрх луг луг хөдлөөд
Булгийн ус пор пор ундраад	Улбар туг намирс намирс мандаад
Хойт руу хор хор хоржигноод	Улаан судал нэвт шувт лугшаад
Хос салаа усан мөчир болоод	Би чи нэг адил нөхөрлөөд
Булт хүүхэд год шод гүйлдээд	Бид нар, та нар нэг хамт жагсаад
Булчин мах эрчлэн мушгиран чангараад	Цог жавхлангаа үүсгэн бадруулаад
Олон хүүхэд ярс ярс жагсаад	Цовоо зангаа гарган хүмүүжээд
Улаан бүч эрвэс дэрвэс хийсээд	Ийм л сайхан
Ийм л сайхан	Тийм л соньхон
Тийм л соньхон	(Ц.Дамдинсүрэн)

**Алхам 2.** Дээрх эхээс дараах үгсийг ялган бичээрэй.

Дуу авиаг илэрхийлсэн  
авиа дуурайх үг

Үйл хөдлөлийн шинжийг заасан  
дүрс дуурайх үг

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Алхам 3. “Алхам 2”- ын хүрээнд ялгасан үгс өгүүлбэрт ямар үгтэй холбогдож, ямар асуултад хариулагдаж байгааг тодорхойлъё. (Өмнөх “Алхам -1”- ийн эх дээр зурж, бичиж ажиллаарай.)

Яаж?  
 Үлгэрлэвэл:
   
 Борооны дусал шивэр шивэр ороод
   
 Яаж?
   
 Булгийн ус пор пор ундраад

Дүгнэлтийг гүйцээж бичье.

Авиа ба дүрс дуурайх үг нь өгүүлбэрт  
 ..... үгтэй холбогдож,  
 ..... гэсэн асуултад  
 хариулагдаж байна.

Алхам 4. Өгүүлбэрт тодруулсан үгийг хасахад үйлийн болц, дүр байдлын утгад ямар өөрчлөлт гарч байна вэ? Өгүүлбэрийг харьцуулж ажиглаад, дүгнэлтийг анхааралтай уншъя.

Хойд зүгт гангар гунгар хийлцэн урамтай л давхилдав.  
 Намрын салхи сэр сэр үлээнэ.  
 Галт тэрэг тар тар таржигнуулсаар зогсоно.  
 Загас жараахай энд тэндгүй пол пол үсэрнэ.  
 Олон одон жирэв жарав гийлцэнэ.

Хойд зүгт урамтай л давхилдав.  
 Намрын салхи үлээнэ.  
 Галт тэрэг таржигнуулсаар зогсоно.  
 Загас жараахай энд тэндгүй үсэрнэ.  
 Олон одон гийлцэнэ.

Дүгнэлт: Эдгээр үгс нь үйлийн байдлыг эрчимжүүлэх, тодчилох үүрэгтэй.

Өөрөөр хэлбэл, үйл хөдлөлийн дүр байдлыг нүдэнд үзэгдэж (дүрслэх үг), чихэнд сонсогдтол (дуурайх үг) дүрслэхэд гол үүрэг гүйцэтгэнэ.

Тухайн үгсийг хассанаар үйлийн шинж тодорхойгүй болно

Алхам 5. “Туулай” шүлгийг уран унш. Дүрслэх, дуурайх үгийн доогуур зурж, эдгээр үг нь үйлийн дүр байдал ба дуу чимээг тоочин дүрслэх чухал хэрэглүүр болохыг ажигла.

Алхам 6. Шүлгийг дуурайн 8 мөрт зохиогоорой. Дуурайж зохиохдоо шүлгийн мөрийн бүтэц нь “Шинж + нэр үг + шинж + үйл үг” байгааг анхаараарай. Жишээ нь: Борхон саарал туулай бөмбөн бөмбөн үсэрч ...

Туулай  
 Борхон саарал туулай  
 Бөмбөн бөмбөн үсэрч  
 Боролж шугуйн дундуур  
 Дэлдэн дэлдэн дэвхрэхэд  
 Босоо хоёр чих нь  
 Сэртэн сэртэн хайчилж  
 Богино хархан сүүл нь  
 Годос годос хөдөлнө.  
 Урьхан хөөрхөн хошуу нь  
 Шөмбөс шөмбөс хөдөлж  
 Урсгал номхон нүд нь  
 Бүлтэс бүлтэс анивхийнэ...  
 (Д.Цэвэгмид)

Миний зохиосон эхийн нэр .....  
 .....  
 .....  
 .....  
 .....  
 .....  
 .....  
 .....  
 .....

Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр

**Дасгал 5.** “Миний эх орон” гэсэн сэдвийн хүрээнд аяллын бяцхан тэмдэглэл бичье.  
(Үгийн тоо 50-60)

Аялсан газраас сэтгэлд чинь хамгийн тод үлдсэн нутгийг сонгон, тоочин дүрсэлж бичье. Бусдын анхаарлыг татаж, сэтгэлийг нь хөдөлгөхийн тулд юу юуг, яаж тоочин дүрсэлж бичихээ бодож төлөвлөө.

Юу юу харагдаж  
байна вэ?

Манан хүдэн

хөшиглөсөн

уулс

Өндөр өндөр

барилга

Юу үнэртэж  
байна вэ?

Аргалын угаа

Борооны

дараах чийг

Юу сонсогдож  
байна вэ?

Болжморын

жиргээн

Машины

нүргээнт чимээ

Ямар ямар үг  
хэрэглэх вэ?

Тэмдэг нэр

Уран дүрслэл

Дүрслэх,

дуурайх үг

Үйлийг

зэрэгцүүлэн

тоочих

Үйл бүр эзэнтэй

Зэрэгцүүлэн

холбох арга

Эхийн бүтцийн  
хэсгийн уялдаа

холбоо

Өөрийгөө үнэлээрэй.

1	Эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог сайн гаргасан уу?	1 2 3 4 5
2	Үйлийг тоочин дүрсэлж чадсан уу? (Үйл явдлыг зэрэгцүүлэн найруулах)	1 2 3 4 5
3	Дүрслэх болон дуурайх үгийг хэрэглэсэн үү?	1 2 3 4 5
4	Зөв бичих болон найруулан бичих алдаагаа хянасан уу?	1 2 3 4 5

Дууссан: .....он .....сар .....өдөр

Сурагчийн нэр: .....

Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр




Гүйцэтгэсэн ажил үүргийн явц, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах зорилгоор үйлдсэн албаны бичиг баримтыг **илтгэх хуудас** гэнэ.

Тоочих найруулга буюу албан бичгийн найруулга нь:

- Үгийг шууд утгаар хэрэглэнэ.
- Уран дүрслэл хэрэглэхгүй.
- Сэтгэлийн өнгө аяс илрэхгүй.
- Баримтад суурилна.
- Санааг товч, тодорхой илэрхийлнэ.
- Баримт бичиг боловсруулах стандартыг мөрдөнө.
- Тухайн баримт бичигт байх ёстой бүрдлүүдийг бүрэн, зөв үйлдэнэ.
- Илтгэх хуудсын бүрдэл: Байгууллагын нэр, баримт бичгийн нэр, тэргүү, он, сар, өдөр, үйлдсэн газар, үйлдсэн хүний гарын үсэг.

**ДАСГАЛ 6.** Илтгэх хуудсын бүтэц, агуулгын уялдаа холбоог мэдэж авъя.

**Алхам 1.** Илтгэх хуудсыг уншиж, бүтэц, агуулгын уялдаа холбоог сайтар ажиглаж, мэдэж аваарай.







**ТООНЫ НЭР:** Аливаа хүн амьтан, юм үзэгдлийн тоо ширхэг, дэс дугаар, хам цуг, бүхэл бутархай, үйлийн хэдэн удаа болсон утгыг заасан үгсийг тооны нэр гэнэ.  
 Бүтцээр нь энгийн, нийлмэл гэж хуваана.  
 Жишээ нь: Энгийн 1. 8 Нийлмэл 25. 896

**ДАСГАЛ 7.** Тооны нэрийн утга, үүргийг мэдье.

**Алхам 1.** Тооны нэрийн утгын ангиллыг анхаарч, мэдэж аваарай. Өмнөх илтгэх хуудсаас дараах хүснэгтэд тохирох жишээг сонгон бичье.

	Тооны нэрийн утга	Тооны нэрийн асуулт	Жишээ	
1	Үндсэн тоо	хэд, хэчнээн	1. 38	
2	Хам тоо	хэдүүл	Хоёул, гурвуул	
3	Тойм тоо	хэд орчим	50 орчим, 20 гаруй	
4	Дахих тоо	хэдэн удаа	3 удаа, 5 удаа	
5	Бутархай тоо	хэдний хэд	Гуравны нэг	
6	Түгээл тоо	хэд хэдээр	Арав арваар	
7	Дэс тоо	хэддүгээр	Хоёрдугаар	

**Алхам 2.** Илтгэх хуудас бичихэд тооны нэр ямар үүрэгтэй байгааг 2 жишээгээр тайлбарлаарай.

.....

.....

**Алхам 3.** Илтгэх хуудсыг тодорхой, үнэн баримтад үндэслэн бичих ёстой. “Номын баяр” сарын аян явуулсан тухай илтгэх хуудсаас 3 баримтыг ялган бичье:

(Баримт бол тухайн үйл ажиллагааг нотлох бодит, тодорхой, үнэн үйл явц, жишээ )

.....

.....

.....

**Алхам 4.** Хийсэн ажлаа баримтад үндэслэн илтгэн бичихийн учир юу вэ?

.....

.....

**Алхам 5.** Албан бичигт хэрэглэж байгаа тоо, баримт буруу, дутуу, хуурамч байвал ямар үр дагаварт хүрэх вэ?

.....

.....

### ДАСГАЛ 8. Илтгэх хуудас бичье.

хэн?	хэнд?	юуны тухай?	яах гэж?	яасан?
Багш Б.Цогзолмаа	Сургуулийн захиргаанд	"Номын баяр" аян явуулсан тухай	Сурагчдыг номтой нөхөрлүүлэх, ном унших хэрэгцээ сонирхлыг нэмэгдүүлэх	Эцэг эхчүүдийг... татан оролцуулсан тухай Эсээ бичлэгийн уралдаан... ...үр дүнтэй болсон тухай.

### Алхам 1: Дараах бүтэц, загварын дагуу илтгэх хуудас бичье.

Байгууллагын нэр: .....

**ИЛТГЭХ ХУУДАС**

Тэргүү: .....

Огноо: ..... Үйлдсэн газар: .....

.....

**Эхлэл:**  
Хэзээ, ямар зорилгоор юу хийсэн бэ?

**Гол:**  
Зорилгын хүрээнд юу юу хийсэн бэ? гэдгийг баримтад үндэслэн бичих

**Төгсгөл:**  
Ямар үр дүнд хүрснээ дүгнэх, санал тавих

Нэр, гарын үсэг:  
ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН: .....(нэр бүтнээр)

### Алхам 2. Бичсэнээ 1-5: хүртэл оноог дугуйлж, өөрийгөө дүгнэе.

- |   |           |
|---|-----------|
| 1. Эхийн бүтэц, загварын дагуу бичиж чадсан                               | 1 2 3 4 5 |
| 2. Хэн?, хэнд?, юуны тухай?, яах гэж?, яаж? гэсэн асуултад хариулж бичсэн | 1 2 3 4 5 |
| 3. Үнэн, тодорхой тоо, баримтад үндэслэн бичсэн                           | 1 2 3 4 5 |
| 4. Найруулгын болон зөв бичих, цэг тэмдгийн дүрмийн алдаагүй бичсэн       | 1 2 3 4 5 |

Дууссан: .....он .....сар .....өдөр

Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр



Танилцуулга – Бусдад танил болгох үүднээс тусгайлан үйлдсэн сурталчилгааны хэвлэмэл бүтээгдэхүүн. (Монгол хэлний их тайлбар толь)

№	Танилцуулга		
	Төрөл	байгууллага, хамт олон, хувь хүний өнгөрсөн, одоо, ирээдүйн зорилго, зорилт, үйл ажиллагааны	ном, зохиол, уран бүтээл, бараа, бүтээгдэхүүн, аливаа шинэ нээлт, технологийн
1	Юуны тухай	шинж чанар, онцлог, давуу талыг	
2	Зорилго	бусдад таниулах, мэдээлэх, сурталчлах	
3	Ач холбогдол	танин мэдүүлэх	
4	Нөлөөлөх байдал	уншигч, сонсогчдыг ятгах, үнэмшүүлэх	

**ДАСГАЛ 9.** Танилцуулгын бүтцийг задлан шинжилж, гол санааг ойлгоё.

**Алхам 1.** Номын танилцуулгыг уншиж, асуултад хариулж бичээрэй.

9 эрдэнийн ганжуур

БНСУ-ын Гуанжу хотноо 2013 оны 6 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд болсон ЮНЕСКО-ийн Олон улсын зөвлөлдөх хорооны 11 дүгээр хурлын шийдвэрээр Есөн эрдэнийн Ганжуур судрыг ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрийн олон улсын жагсаалтад бүртгэсэн.

110 боть Есөн эрдэнийн Ганжуур их хөлгөн судрыг 1819 онд бүтээжээ. Буддын шашны дээд судар болох энэхүү Ганжуур нь далан түрүү, банлиг, замбага цэцэг зэрэг ургамлыг тусгай арга технологийн дагуу боловсруулан 4-9 давхарлан нааж бүтээсэн хар цаасан дээр монголчуудын эрхэмлэж ирсэн, уламжлалт нарийн аргаар боловсруулсан алт, мөнгө, шүр, сувд, номин, оюу, зэс, тана, ган хэмээх 9 эрдэнээр тодорхой дэс дараалалтайгаар бичсэн нэн ховор судар юм. Есөн эрдэнийн Ганжуур нь урлагийн сонгодог өв, эрдэнээр бүтээсэн ном судруудын оргил бүтээл болж үлдсэн бөгөөд ийм хэмжээний хөлгөн их судрыг урьд өмнө ч, өнөө хэр ч өрнө, дорно дахины улс түмнүүд бүтээгээгүй байгаа билээ.

Уг судар нь хуучин Их хүрээний Зүүн дацан буюу Дашчойнпил дацанд залагдаж байгаад 1937-1938 онд МУУНС-ийн сан хөмрөгт шилжжээ. Монгол улсын Засгийн газрын 2002 оны 118 дугаар тогтоолоор “Хосгүй үнэт” өвд бүртгэгдсэн байна.

Энэ танилцуулгын зорилго нь юу вэ?

Чухалчилсан санаа, шинэ мэдээлэл юу байв?

.....

.....

.....

Чамд юу юуг танилцуулсан бэ?

Уншигчдад нөлөөлөх, бахархах сэтгэгдэл төрүүлсэн өгүүлбэр, хэсэг байна уу?

Эхлэл:..... Жишээ нь:.....

Гол:.....

Төгсгөл:.....

.....

Алхам 2. Юу юуны танилцуулга байж болох вэ? Гүйцээж бичье.

Алхам 3. Номын танилцуулгаас уншиж, хэрхэн бичих санаа авъя.

Хорин жилийн өмнө анх дэлхийн өнцөг булан бүрд суугаа уншигчид Ж.К.Роулингийн бичсэн гайхамшигт "Харри Поттер ба философийн чулуу" зохиолтой танилцаж байсан билээ. Тэр цагаас хойш энэхүү ном долоон боть болж хагас тэрбум уншигчдын гарт хүрсэн билээ. Дэлхий даяар арван таван хүн тутмын нэг нь Харри Поттерыг уншжээ. Ная гаруй хэл дээр орчуулагдсан энэхүү цувралыг бид монгол уншигчдадаа албан ёсны эрхтэйгээр орчуулан хүргэсээр байна. Харри Поттерын адал явдлуудыг өгүүлэх долоон боть номын гурав дахь нь болох "Харри Поттер ба Азкабаны хоригдол" нь уншигчдын хамгийн дуртай зохиол юм. Харригийн адал явдал үргэлжилсээр...

Номын танилцуулга бичихэд авах санаа:

Номын танилцуулга бичихэд авах санаа:

... "Бүхий л биед чинь нэвт уусан шингэж, тэр мэдрэмж рүү чинь чамайг ахин дахин эргүүлэн дуудаж, ингэх бүртээ гэнэтийн бэлэг барьж, баяр жавхланг мэдрүүлэх тийм л зохиол..."

...Номыг уншаад нисмээр🦉, бүжиглэмээр🦉, амьдралыг хайрламаар♥️, байгаа бүхэндээ талархмаар🙏, аялмаар🌍📖 ихийг хийж бүтээмээр👉, улам их хичээмээр👉 нэг л тийм хөнгөн мэдрэмж төрөх вий.

... Хүн сэтгэлийн амар амгаланг гаднаас бус дотроосоо хайж олсон цагт өөрийгөө аз жаргалтай хүн болгож чаддаг гэдгийг энэ ном танд харуулаад зогсохгүй... энэхүү сэтгэл хөдөлгөм түүх нь илүү их урам зоригтой, тэнцвэртэй, баяр баясгалантай амьдралд хүрэх аргад таныг алхам алхмаар сургах болно.

**Дасгал 10.** Өөрийн уншсан номоос чиний сэтгэлд хоногшсон, чиний амьдралд хамгийн их нөлөөлсөн, бусдыг уншаасай гэсэн номынхоо танилцуулгыг бичье.

Номын танилцуулгын нэр (Оновчтой, сонирхолтой, анхаарал татахаар)

.....

Номын нэр,  
зохиогч, номын  
гол, үнэ цэнтэй  
санаа юу вэ?

Blank box for writing the title and author of the book.



Large blank box for writing the main review text.

Энэ номыг уншвал хайж буй зүйлээ олохыг, асуудлыг шийдэхэд чинь яаж туслахыг бичвэл сайн.  
  
Чамд амьдралын ямар бэрхшээлийг даван туулахад яаж тусалсан бэ?... гэдгийг баримтаар бичвэл сайн



Уншигчид номоос ямар ухаан олж авах, тэдний ирээдүйд хэрхэн сайнаар нөлөөлөх талаар бичвэл сайн

Blank box for writing the impact of the book on the reader.



Blank box for writing the date of completion.

Тэднийг уншихад уриал.  
  
Сэтгэл хөдөлгөм уриалга бичээрэй.



Дууссан: .....он .....сар .....өдөр